

3

**ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЫГ ЗААХ
АРГЫН ЗАРИМ АСУУДАЛ****Г.Миеэгомбо**

Орчин үед ШУТ-ийн дэвшлийн шинэ эрин үетэй уялдсан дээд боловсролын агуулга бүтэц, зохион байгуулалт, стандарчлал шинэчлэгдэн өөрчлөгдлөө. Энэ нь эдийн засгийн онолын хичээлийг заахад тусгалаа олж, бид дэлхий нийтийн жишээгээр, цоо шинэ маягаар судлах, суралцах мэдлэгээ үнэлж, дүгнэдэг болж байна. Дээд боловсролын агуулгын эдгээр өөрчлөлт шинэчлэлтийн гол цөм нь оюутан төвтэй сургалт юм. "Чамайг сургана", "Чамд үйлчилнэ" гэсэн сургалтын ажлын үр өгөөж нь агуулгын шинэчлэлээс хамаарахаас гадна багш хүн оюутныг ямар арга барилаар яаж сургах вэ гэдгээс ихээхэн хамаарна. Үүнтэй холбогдон заах арга зүй биеэ даасан судлах асуудал болон тавигдаж байна. Ямарч хичээлийн заах арга зүй нь өөртөө судалгааны объекттой, судлах зүйлтэй байдаг. Заах арга зүйн судалгааны объект нь хичээл сургалтын процесс юм. Заах арга нь аливаа шинжлэх ухааныг судлах, заах зүй тогтлыг судална. Заах арга, дидактик хоёр хоорондоо ялгаатай.

Дедуктик нь сургалтын ерөнхий зүй тогтол, түүний төрөл, хэлбэрийг хичээлийн төрлөөс хамааруулахгүйгээр ерөнхийд нь хийсвэрлэж судалдаг.

Заах арга бол тодорхой төрлийн хичээлийг сургах арга, хэлбэрийн онцлог, сургалтын процессийн өвөрмөц зүй тогтлыг судалдаг. Үүнээс үзэхэд заах арга бол тухайн хичээлийг сургах нэг өвөрмөц онол юм. Тодорхой нэг хичээлийн сургалтын процессийн өвөрмөц зүй тогтлууд нь тэр хичээлийн агуулгаас урган гарч байна. Тухайн хичээлийн агуулгатай холбогдоод заах арга ялгаатай байдаг.

Эдийн засгийн онолыг амжилттай заахын тулд түүний агуулга, бүтэц, үндсэн агуулгыг сайтар мэдэх, түүнийг заах аргыг эзэмших хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, материалыг чөлөөтэй ашиглах, хэдийд, хаана ямар арга барил, техник хэрэгслийн тусламжтайгаар ямар асуудал, сэдвийг бүрэн хэмжээгээр

нээн харуулж чадах вэ? гэдгийг мэдэж авна гэсэн үг юм. Гялалзсан илтгэгч, нэрд гарсан сурган хүмүүжүүлэгчид цөм тухайн шинжлэх ухааны онцгой мэдлэгтэй, заах аргын ур чадвартай хүмүүс байдгийг бид мэднэ. Илтгэгч хүн сонсогчиддоо хамгийн сайн нөлөө үзүүлж чадах урлаг бол заах аргын ур чадвар юм. Сайн илтгэгч хүний хэлсэн ярьсан бүхэн нь өөрийн логик сэтгэлгээ, энгийн, яруу тод байдал, ярианы үнэмшүүлэх чадвараараа сонсогчдоо бүрэн эзэмдэж чадсан байдаг.

ЭЗО-ыг заана гэдэг нь сургалтын материалыг оюутнууд хүлээж авах, эзэмших процесс төдийгүй, уг хичээлээр дамжуулж оюутныг бие хүний нь хувьд төлөвшүүлэх, хүмүүжүүлэх үйл ажиллагаа явуулна гэсэн үг юм. Бидний хүсэж байгаа хүмүүжлийн ажлын үр өгөөж нь багш хүн хичээл заах явцдаа хүмүүжүүлэх зорилтыг зориуд дэвшүүлж, түүнийгээ хэрэгжүүлсэн үед, сургалтынхаа агуулга, арга, хэлбэрийг үүндээ тохируулж зөв сонгосон үед л уг зорилтыг шийдвэрлэж чаддаг.

ЭЗО-ын хичээлийн заах аргын судлах зүйл нь сургалт, хүмүүжлийн ажлын агуулга, зорилтыг тодорхойлсон, уг зорилтыг биелүүлэх ажлын үр ашигтай арга хэрэгслийг боловсруулсан сургалт хүмүүжлийн ажлын өвөрмөц зүй тогтол юм. Үүнээс үзэхэд заах арга бол онол, практикийн асуудлыг аль алиныг багтаасан мэдлэгийн бие даасан салбар юм. Заах аргын агуулга “юунд сургах, яаж сургах?” гэсэн өргөн хүрээтэй онол, практикийн асуудлууд багтаж байна.

Дээд сургуулиудын өмнө тавигдаж буй “юуны төлөө сургах хэрэгтэй вэ?” гэсэн зорилттой холбогдуулан заах арга нь сургалт хүмүүжлийн ажлын агуулга, зорилтыг тодорхойлж байдаг. Үүний хүрээнд дээд сургуулийн сургалтын агуулга, сурах бичиг, хичээлийн хөтөлбөр, сургалт арга зүйн бусад материалыг боловсруулах, сайжруулж байх асуудал багтана. Түүнчлэн байнга хөгжиж, баяжиж байдаг сурган хүмүүжүүлэх ажлын туршлагыг судлах, онолын хувьд нэгтгэн дүгнэх явдал үүнд бас багтана.

Заах аргын агуулга нь түүний судлах зүйлийг бодвол илүү хувьсамтгай байдаг нь багшийн өмнө тавигдаж буй тодорхой зорилт, зааж буй шинжлэх ухааны хөгжлийн түвшин, багш хүний өвөрмөц онцлог, баримталж буй арга зүй, түүнчлэн сургалтын процесс нь сургалт арга зүйн материал, техник хэрэгслээр аль хир хангагдсан зэрэгтэй холбоотой юм. Заах аргын агуулгад тухайн шинжлэх ухааныг заахтай холбогдсон нийтлэг ба өвөрмөц зарчмууд бас багтана.

Сургалт явуулах ажлын шинжлэх ухаан, онолын түвшинг тогтоох, оюутнуудад ертөнц, орчноо ойлгоход туслах, судлах материалаа утга санааны уялдаа сайтай, баримт нотолгоотой илэрхийлэх чадвар суулгах, сургалтын явцад илэрч буй сэтгэл зүйн зүй тогтлыг тооцох зэрэг шаардлагуудыг харгалзаж үзэх нь чухал юм.

Энэ бүх шаардлагуудын тогтолцоо нь уг хичээлийг заах аргын ертөнцийг үзэх үзэл, арга зүй, логик, сэтгэл зүйг бүрдүүлж өгнө.

Эдгээр шаардлагуудыг биелүүлснээр дээд сургуулийн өмнө дэвшигдэж байгаа багшлах ажлын зорилтуудыг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл бүрдэнэ.

ЭЗО-ын заах арга нь нийгмийн хэрэгцээ, багшлах ажлын практикаас уламжлан дараах онол, практикийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Багш хүнийг багшлах ажилдаа бэлтгэл муутай, урсгалаараа, харалган хандуулахгүйн тулд заах аргын шаардлагатай түвшингийн мэдлэгээр зэвсэглэх хэрэгтэй юм.
2. Багшлах ажлын шинжлэх ухааны үндэстэй, үр ашигтай арга барил эзэмшүүлснээр түүнийг асуудалд өөрийн байр суурьтай хандах, элдэв харш онол, үзэл баримтлалыг үндэслэлтэй тайлбарлаж, няцааж чаддаг болгох.
3. Шинжлэх ухаан техникийн дэвшил нь сургалтын процессыг эрчимжүүлэх богино хугацаанд чухал, хэрэгцээтэй мэдлэгийг аль болох ихээр өгөхийг хичээхтэй холбоотой. Ийм нөхцөлд сургалтын процессийг зохистой зохион байгуулах нь практикт сургалтын шинжлэх ухааны үндэстэй шинэ арга барил нэвтрүүлэх, орчин үеийн техник хэрэгсэл хэрэглэснээр хянагдаж чадах юм.

Эдийн засгийн онолын заах арга зүйн үндсүүд

Арга зүй гэдэг ойлголтод байгаль, нийгмийн бодит хуулинд тулгуурласан танин мэдэхүйн хамгийн нийтлэг аргыг хамааруулж авч үздэг. Арга зүйн үндэс нь асуудалд диалектикийн үүднээс хандах явдал юм. Танин мэдэхүйн ерөнхий арга болсон диалектикийн аргын зэрэгцээгээр судалж багйаа зүйл тус бүртээ тохирсон тусгай аргууд байдаг. Жишээ нь эдийн засгийн онолын судалгааны арга зүйн тухай авч үзье. Эдийн засагт хоёр төрлийн сэтгэлгээ байдаг. 1-рт, ерийн буюу энгийн. Энэ нь аж ахуйн амьдралын өнгөц орших учир шалтгаанаар үүссэн эдийн засгийн холбоо хэлхээг илэрхийлдэг. Жишээ нь өрсөлдөөн ба эрэлт, нийлүүлэлтийн харьцааны өөрчлөлт гэх мэт. 2-рт, шинжлэх ухааны сэтгэлгээ. Жирийн ажиглалтаар илрэхгүй хүчин зүйлүүдийн нөлөөгөөр бий болсон аж ахуйн дотоод хэлхээ холбоог илэрхийлнэ. Жишээ нь өртгийн хөдөлмөрийн онолоор зах зээл дээрх үнийн хэлбэлзлэлийн цаана дотоод процес буюу үнэ, өртгийн хамаарал оршиж, түүнийг судалгааны тодорхой аргаар илрүүлдэг. Ерийн сэтгэлгээ нь өнгөц ажилгалтаар тогтоосон ойлголт, аж ахуйчлалтын адил төстэй шинжүүдийг гадна талаас нь нэгтгэн дүгнэснээр аж ахуйн үйл ажиллагааны чиг баримжаа, дүрэм заавар үүсдэг. Энэ сэтгэлгээ эдийн засгийн үйл явцын нэг талыг өрөөсгөлөөр илэрхийлдэг. Шинжлэх ухааны сэтгэлгээ бол гадаад ертөнцийг бодит дүр төрөхөөр нь дүрсэлж, эдийн засгийг олон талаас нь бүхэлд нь тусгадаг. Шинжлэх ухааны судалгаанд хэрэглэгддэг олон арга байдаг. Үүнд:

- Түгээмэл арга (философийн). Танин мэдэхүйн бүх хүрээнд үйчилдэг. (диалектик)
- Шинжлэх ухааны ерөнхий арга. (түүхэн, логик, математикийн гэх мэт)
- Өвөрмөц арга (тухайн салбарын). Эдийн засгийн шинжлэх ухаанд эсрэг
- тэсрэг хоёр арга хэрэглэгддэг ба ялгаа нь юугаар илэрхийлэгдэх
- Тусгай арга зүй. Танин мэдэхээс гадна сургалт, судалгаандаа хэрэглэж сурах нь түүнээс дутуугүй чухал.

Эдийн засгийн үзэгдлүүдийн харилцан холбоо, харилцан нөхцөлдсөн зарчмуудыг эдийн засгийн онолын хичээлүүдийн жишээгээр харуулж болох юм. Энэ нь үзэгдэл юмст системчилж хандана гэсэн үг юм. Жишээ нь бүтээмжийн асуудалд үйлдвэрлэлийн хүчин зүйл тус бүрийн үр өгөөжийг авч

үзэхийн хамт хөдөлмөрийн бүтээмжийг хүмүүсийн мэргэжил, чадвар, дадлага, техник зэвсэглэмж зэрэгтэй холбож, эдгээрийн харилцаа холбоог тодорхой тогтолцоонд оруулан, нэгтгэн судлах нь түүний учир шалтгаан, үр дагаврыг тодруулахад туслана. Энэ чанараараа ч хөдөлмөрийн бүтээмж үйлдвэрлэлийг өсгөх гол хүчин зүйл болж байдаг билээ. Диалектик зарчмын нэг илрэл нь асуудалд түүхэн үүднээс хандах явдал юм. Эдийн засгийн онолын хичээлийн олонхи асуудал түүхэн зарчмын үндсэн дээр судлагдаж байна. Ямар ч тодорхой асуудлыг судлахад түүхэн хөгжлийн явцад уг асуудал яаж үүссэн, ямар үе шатуудыг дамжсан, одоо ямар болоод байгааг тодруулах ёстой болдог. Жишээ болгож эдийн засгийн сэтгэлгээ хэрхэн үүсч хөгжөөд байгааг авч үзье. Улс орны баялгийн эх үүсвэр нь юу вэ гэсэн зорилтыг шийдвэрлэхтэй холбогдоод эдийн засгийн шинжлэх ухаан XVII-XVIII зууны заагт үүсчээ. Үүнд тайлбар өгөх чиглэлээр эдийн засгийн ухаан олон үе шатыг дамжив.

1. Маркентализм. (Эхэн үеийн XV-XVI зууны үе, хожуу үеийн XVI-XVII зууны үе). Худалдаагаар дамжуулан хуримтлуулах нь баялгийн гол эх сурвалж гэж үздэг.
2. Сонгодог улс төр эдийн засгийн ухаан. Эх үүсвэр нь үйлдвэрлэлийн процесс гэж үздэг. Энэ үед эдийн засаг, эд юмсын мөн чанар, зүй тогтлыг судалдаг шинжлэх ухаан шинжтэй болсон. Физиократ- Ф.Кенэ. ХАА-г товойлгосон. Английн сонгодог- А.Смит, Д.Рикардо. Хөдөлмөр бүхний эх үүсвэр гэж үзсэн. У.Петти "Баялгийн эх нь газар, эцэг нь хөдөлмөр" гэж үзсэн.
3. XIX зуунд шинэ сонгодог онол эрч хүчээ авсан гэх мэт.

Ийнхүү сургалтын материалд түүхэн зарчмыг тууштай тусгах нь хичээл заалтын шинжлэх ухаан, онолын түвшин, оюутан хүний ерөнхий соёлыг дээшлүүлэх, тэднийг асуудалд бүтээлчээр шүүмжлэлтэй хандахад сургана.

Диалектикийн хуулиуд нь бодит шинжтэй бөгөөд байгаль, нийгэм, хүний ухамсарт оршин, үйлчилж байдаг. Эдгээр хуулиуд нь хөгжлийн эх үүсвэр юунд байгаа, хөгжил ямар чиглэлд яаж явагддагт хариулт өгдөг. Хөгжлийн эх үүсвэрийн асуултад эсрэг тэсрэгийн нэгдэл тэмцлийн хууль хариулт өгнө. Эсрэг тэсрэгийн хоорондын харилцаа нь эдийн засгийн үзэгдлүүдийн мөн чанарт тусгалаа олсон дотоод зөрчил болж илэрдэг бөгөөд тэдгээрийн хөгжих үндсэн эх үүсвэр нь болдог. Жишээлбэл хувь хүний хөгжлийн эх үүсвэр нь өөрчлөгдөн хувьсаж байдаг хэрэгцээ, түүнийг хангах бодит бололцооны хоорондох зөрчил юм. Хүмүүсийн бодит хэрэгцээ хангагдахын хирээр хэрэгцээний хүрээ өргөжиж агуулга нь сайжирч, зөрчил нь арилна. Бас нэг өөр төрлийн зөрчил гэвэл хөдөлмөр, сурлагын процесст хүмүүст тавигдаж буй шаардлага, тэдний бэлтгэгдсэн (мэдлэг, чадвар, туршлагын хувьд) байдал хоёрын хоорондох зөрчил юм. Сургалтын процесст бэлтгэлийн түвшин дээшлэх тутам хүмүүсийн тавих шаардлагын хэмжээ өсч ирнэ. Диалектикийн өөр нэг хууль гэвэл хөгжлийн процесс яаж явагддагт хариулт өгнө. Тооны хувьсал хуримтлагдсаар хэрхэн чанарын өөрчлөлтөд шилжих тухай. Сэтгэхүйн ялгаа наснаас хамаарч хэрхэн өөрчлөгдөх тухай өөр нэг жишээ гэвэл суралцаж буй ангийн ялгаанаас болж, сурагчдын сэтгэл зүй энгийнээс нарийсч, анги ахих дутам суралцах үүргээ ухамсарлах, өөртөө болон хамт олондоо, биеийн болон окуны

бололцоондоо хандахад чанарын өөрчлөлт гарч болдог. Эдийн засгийн онолыг заах явцад нэг талаас диалектикийн хууль, үндсэн зарчмыг баримтлах, нөгөө талаас сэдвүүдийн шинжлэх ухааны онолын түвшинг бууруулахгүй байх шаардлагыг хангах ёстой юм. Энэ нь уг хичээлийн шинжлэх ухааны чанарыг хангах явдал юм. Шинжлэх ухааны чанар гэж яриандаа олонтой давтсанаар хангагдахгүй ба хамгийн гол нь бодит зүй тогтлуудын бодит шинж, түүний хүний санаа зоригоос хамаардаггүй байдлыг чадварлаг гаргах явдал юм. Материалаа түүхчлэн тоочих бус онолын хувьд үндэслэх нь илтгэгчийн анхаарлын төвд байх ёстой. Үүний тулд баталгаатай, үндэслэгээтэй, туршлага практикаар нотлогдсон байдлаар буюу өмнө нь ярьж нотолсон үнэлгээ, дүгнэлтүүдээс ургуулан бодож гаргасан байх шаардлагатай юм. Багш хүний хэлэлцүүлэг, нотолгоонд утга санааны тасалдал, авцалдаагүй санаа, дүгнэлт гарах ёсгүй юм. Өөрийн эргэцүүлэн бодох үйл ажиллагаандаа багш хүн шинжлэх ухааны баталгаа нотолгоог хоосон яриа, лоозогносон үг хэллэгээр солих нь оюутнуудын сэтгэн бодох үйл ажиллагааг идэвхижүүлэхгүй, материалыг хуулбарлан хүлээж авах, механикаар үгчилэн цээжлэхэд хүргэж тэдэнд шинжлэх ухааны үзэл баримтлал бүрэлдэхэд нөлөөлж чадахгүйд хүрнэ.

Хичээл заалтанд шинжлэх ухааны чанарыг баримтлах нь илтгэгч хүн тухайн шинжлэх ухааны урьдчилан таамаглах үүргийг илрүүлж байна гэсэн үг.

Онол, практикийн холбоо ба заах арга

Шинжлэх ухаан, практикийн холбоо хоёрдмол шинжтэй. Нэг талаас, хүмүүсийн амьдрал практик үйл ажиллагаа шинжлэх ухаанд шинэ зорилт, шинэ хэрэгцээ дэвшүүлж түүнийгээ шийдвэрлэхийг шаардаж байдаг. Нөгөө талаас, шинжлэх ухаан нь шинэ материал, үнэлгээ дүгнэлтүүдээр баяжин, хөгжихийн зэрэгцээгээр түүнийгээ практикт туршиж, нэвтрүүлж түүгээрээ амжилт бүтээлээ тодорхойлж байдаг. Онол, практикийн холбоог багш хүн сургалтын болон сургалтын гадуурх төрөл бүрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Энэ нь багш хүн ЭЗО-ын хичээлийг заахдаа зөвхөн түүнийг мэдүүлэхийн төлөө бус, онолыг практикийн үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг болгоход оршино. Мөн Эдийн засгийн онол нь хүмүүсийг аж ахуйн үйл ажиллагаанд сургаж, өөрийгөө хүмүүжүүлэхэд болон хүмүүсийн сэтгэл санаанд байгаа үл итгэх харш үзэл бодлоос нь ангижруулахад туслана.

Практиктай аль хир нарийн холбоотой байх нь уг шинжлэх ухааныг орчин үеийнх нь түвшинд зааж чадаж байгаа эсэхээс хамаарна. Үүний тулд уг шинжлэх ухаанаар гарч ирж буй шинэхэн дэвшилтэт өөрчлөлтийг багш өөрөө сайн мэдсэн байх ёстой.

- Хичээлийг амьдрал, практиктай холбоход тухайн хичээлийн сэдэвт холбогдох жишээ материалаа онож сонгох нь чухал.
- Онол практикийн холбоог хянахад хичээл зааж буй газрынхаа чиглэл, зориулалтыг харгалзах ёстой. Хичээл заагч нь тэр салбарын талаар наад захын мэдлэгтэй байна гэсэн үг. Ингэхгүйгээр хичээлийн хүмүүжүүлэх нөлөөг бууруулахад хүрнэ.

- Практиктай ойртуулах ажлыг сургалтын төлөвлөгөөгөөр тогтоож өгдөг. Багшлах болон сургалт үйлдвэрлэлийн дадлагын үед өмнө нь заалгасан онолын мэдлэгээ лавшруулж бэхжүүлж, мэдлэгээ итгэл үнэмшил болгоход тусалдаг.
- Багшлах дадлагын үед онол, практикийн холбоо хэрэгжих нь өөр маягаар явагддаг. Энэ үед оюутан хүн уг шинжлэх ухаанаа сурталчлагч илтгэгч, багшийн үүрэг гүйцэтгэнэ.
- Онол практикийн хослолыг хангах нэг чухал ирээдүйтэй зам нь оюутнуудыг тэнхимийн эрдэм шинжилгээний ажил болон аж ахуйн байгууллагын төсөл, гэрээт ажилд оролцуулах, үйлдвэр аж ахуйн газруудад социологийн судалгаа хийлгэх, эрдэм шинжилгээний дугуйлан, клуб, бага хурлын ажиллагаа, уралдаан тэмцээнд оролцуулах явдал чухал юм.

Хичээл заалтын логик арга

Багш хүн бол логик сэтгэлгээ, соёлыг эзэмшин, түүнийгээ үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх ёстой юм. Лекцээ шинэ материалд тулгуурлаж уншихдаа логикийг хэрхэн хэрэглэх тухай авч үзье.

Лекц нь багшлах ажлын гол хэлбэр сургалт, хүмүүжлийн ажлын нэгдмэл илэрхийлэл юм. Багш хүн өөрийнхөө ажилд яам, байгууллагынхаа захиргаанаас баталсан сургалтын төлөвлөгөөг удирдлага болгодог ба түүнд нь заах хичээлийн сэдэв, хамрах хүрээ хатуу тогтоогдсон байдаг. Багш өөрийнхөө сонголтоор лекцэндээ багтаах асуултаа тодруулж, түүнийгээ баримтлан лекцийнхээ агуулга, яс модыг босгоно. Өөрийн мэдлэг, дадлагадаа тулгуурлан логик сэтгэлгээний хууль шаардлагуудыг удирдлага болгон, үндсэн болон нарийн төвөгтэй асуудлынхаа байдалд тохируулан онол практикийн материалыг зохистой хослон лекцийнхээ төлөвлөгөөг хийнэ. Бид түүхэн аргын талаар өмнө ярьсан. Түүхэн арга өөрийн дутагдалтай. Түүхийн баялаг материалтай ч эдийн засгийн онолын судалгаа бэрхшээлтэй тулгарах нь цөөнгүй. Түүхэн аргаар эдийн засгийн тогтолцооны адил төсөөтэй, нийтлэг шинжүүдийг илрүүлж чадахгүй юм. Ийм дутагдлыг даван туулахад логик арга тусалдаг.

Логик арга бол сэтгэн бодох нийтлэг хэлбэрүүд (ойлголт, сэтгэн бодох, учирлан дүгнэх) ба хэрэгслүүдийг тодорхойлсоноор нэг төрлийн сэтгэн бодолтоос нөгөөд шилжих зүй тогтлыг үндэслэн сэтгэн бодох үйл ажиллагааны хуулиудыг зөв хэрэглэх бололцоог олгоно. Энэ нь ярьсан зүйл, хийсэн дүгнэлтүүдийн үнэн мөнийг олоход тусална.

Логикийн дүрэм горимыг зөрчсөний илрэл нь эдийн засгийн үзэгдлүүдийг ангилахад гардаг.

Логик гэлэг нь аж ахуйн бодит амьдралын процессуудын хооронд бий болсон учир шалтгаан- үр дагаварын холбоог зөв бөгөөд гүнзгий ойлгох бололцоо олгодог шинжлэх ухааны хэрэгсэл юм.

Проф П.Кейнс – инженер менежерүүдээс эдийн засагчийн ялгагдах нь нийтэд илэрхий үзэгдлүүдийг системчилж янз бүрийн юмс хоорондоо яаж холбогддогийг тэд сайн мэддэг. Түүний хэлсэнээр "нийгмийн харилцаа холбоо бүхий өргөн хүрээтэй асуудлаар тэд илүү логиктай сэтгэн боддог."

гэжээ. (Эконом.образ мышления м.1991 с.699) Эдийн засгийн онолын логик бүтэц нотлогдох чанар нь ХХ зууны II хагаст математик болон статистикийн гэсэн тусгай хэсгүүд эдийн засгийн шинжлэх ухаанд гарч ирсэнээр сайжирч, үүний дүнд дэлхийн эдийн засгийн шинжлэх ухааны түвшин дээшилж ирсэн. 1969 оноос Шведийн шинжлэх ухааны академаас эрхлэн эдийн засгийн ухаанаар Нобелийн шагнал жил бүр олгодог болжээ. Одоо 40 гаруй хүнд олгоод байгаа. Эдгээр бүтээлийн онцлог нь эдийн засагт математикийг бүтээлчээр хэрэгсэнд оршино.

Өнгөц хэлбэрийн логик нь хүмүүсийн сэтгэлгээний хэлбэр, бүтцийг судалдаг. Энэ логикийн шаардлагыг хэрэгжүүлсэнээр хүмүүс өөрийн сэтгэлгээг зөв зүйтэй, тууштай илэрхийлэх боломжыг олно. Өнгөц хэлбэрийн логикийн шаардлагын үүднээс багш хүн уг яриагаа эсвэл нэгтгэн дүгнэх эсвэл ерөнхийгөөс хэсэгчилсэнийг нотлох аргаар хийж болно. I тохиолдолд сургалтын материалаа баримт сэлт тоочихоос эхлэж яриад эцэстээ сонсогчдоо ерөнхий дүгнэлтэд хүргэдэг. Жишээ нь инфляцийн төрлүүдийг тоочоод эцэст нь энэ бүхэн бол мөнгөний ханш уналтын илрэл юм. Гэсэн дүгнэлт хийж болох юм. Эсвэл үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тухай материал цуглуулаад үр дүнд нь эд бүхэн үйлдвэрлэл явагдах, хөгжих нөхцөл гэсэн дүгнэлт хийх г.м. Дедуктив арга.(ерөнхий хэсэгчилсэний нэг) Судалж буй зүйл ихэвчлэн ерөнхий томъёололыг эхэлж өгөөд дараа нь түүнийгээ жишээн дээр задалж тайлбарлах.Ж:=нь Ажиллах хүчний тодорхойлолтыг (чадвар, мэдлэг, туршлага) өгөөд дараа нь бүрдүүлэгч хүчин зүйлүүдийг тус бүрт нь тайлбарлах.

Багшлах ажлын сэтгэл зүйн асуудлууд

Энэ нь сургалт- хүмүүжлийн процесст чухал ач холбогдолтой. Багш хүний ажил бол хүний сэтгэл зүй, оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөн, зориг эрмэлзлэлийн талд идэвхитэй нөлөөлдөг, хүнтэй ажиллах ажил юм. Сургалтын процесс нь зөвхөн багшаас оюутанд төдийгүй багш, оюутны хоорондох харилцан бие биендээ нөлөөлөх үйл ажиллагаа юм. Энэ процесст багш хошуучлах үүрэгтэй. Багш хүн хүн тус бүрийн сэтгэл зүйн онцлогийг харгалзаж чадахгүй ч оюутан хүнд сургалтын материалыг илүү сайн хүлээн авч эзэмшүүлэх арга зүйн хэлбэр, хэрэгслийг ашигласнаараа тэдний зонхилох хэсгийн анхаарал, сонирхлыг өөртөө татаж чадах юм. Багш хичээлээ олонход ойлгомжтой хүртээмжтэй болохуйцаар зохион байгуулж заах мөн зарим нарийн төвөгтэй, эргэлзээтэй зүйл бүхэнд хариулт өгөх албагүй гэдгийг харгалзах ёстой.Мэдлэг эзэмших процесс шинэ материал хүлээн авахаас эхлээд уг материал оюутны хувийн ойлголт болж түүнийгээ тайлбарлаж, хэрэглэж, чаддаг болсноор тогтдог юм. Хүний үйл ажиллагааг идэвхжүүлдэг гол зүйл нь хүмүүсийг бүтээлч сэтгэлгээ, идэвхтэй үйл ажиллагаанд уриалан дуудах явдал юм. Сонирхолд нь зохицсон сургалт, үр өгөөжтэй, хүний дуртай хоол сайн шингэдэг шиг амархан эзэмшигддэг байна. Багш чухам яаж оюутнуудын сонирхлыг өөрийн хичээлд татах тухай арга зүйн хэд хэдэн тодорхой барил байдаг. Үүнд:

1. Сургалтаа хийсвэр биш нийгмийн практик, оюутны хувийн сонирхол, ирээдүйн амьдралын төлөвлөгөөтэй холбож явуулах.

2. Оюутныг сургалтын процесст сонирхолтой хандуулах урьдчилсан нөхцөл нь заагдах хичээлийн агуулга, бүтэц, үндсэн зүй тогтлууд тодорхой байх явдал юм
3. Суралцах хичээлдээ сонирхол нь нэмэгдэх нэг үндэс бол оюутан хүнд өөрийн хүч, бололцоогоороо итгэлтэй хандах, ололт амжилтаа ухамсарлах сэтгэлгээ бий болгох явдал юм. Оюутны бололцоонд нь тохирсон даалгавар өгч, түүний биелэлтээр нь урамшуулах нь чухал.
4. Амжилт гаргах итгэл төрүүлэхэд оюутны мэдлэгийг тодорхой хугацаанд системтэй үнэлж, хариуг тэр даруйд хэлж, байх нь өөрийгөө сайн, муу талаас нь үнэлэхэд тус болдог.
5. Сургалтын ажлын янз бүрийн хэлбэрүүд нь өөрийн агуулгаараа төдийгүй, цаашид бие дааж сэтгэн ажиллахад бэлэн материал өгч байдагаараа илүү сонирхол татдаг. Оюутанд эрэгцүүлэн бодох юм үлдээгүй цөмийг нь хэлээд өгчих нь сул тал болж харагддаг.
6. Сургалт судалгааны ажилд сонирхол төрүүлэхэд зааж буй зүйлийнхээ түүхээс ярих, мэдлэгийн аль нэг хүрээний үүсэл, хөгжил, шинжлэх ухааны нээлт, энэ салбарт холбогдолтой нэрт хүний намтраас ярих нь зүйтэй.
7. Багшийн өөрийн нь үлгэр дууриал ажилдаа сонирхолтой, мэдлэг зан харьцаа сайн байх нь оюутны суралцах идэвхийг өрнүүлэхэд ихээхэн тустай байдаг.

Оюутнууд сургалтын материалыг хүлээн авах, эзэмших ажлын үр өгөөж нь оюутны хуримтлуулсан туршлага мэдлэг, нийгмийн байр суурь, хүмүүжил, түүний сэтгэлийн хөдөлгөөн, эзэмшиж буй зүйлдээ харьцаа харьцаа, мэдлэг чадвар эзэмшсэн байдал зэргээр илэрхийлэгдэнэ.

Сургалтын аргыг 2 ангилж болох юм.

Нэгдүгээрт: Тайлбарлаж үзүүлэн таниулах арга. Энд онолын асуудлыг жишээ баримт, үзүүлэн материалаар нотлох, мэдлэг түүнийг амьдралд хэрэглэхийн чухлыг зааж өгөх байдлаар хичээл заагдана. Энэ нь оюутанд оюун санааны хөгжил, бүтээлч сэтгэлгээ төрүүлэхгүй байдаг дутагдалтай талтай.

Хоёрдугаарт: Асуудал дэвшүүлж заах арга хэрэглэх. Энэ нь танин мэдэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ. Энэ аргын агуулга нь оюутан багштайгаа хамтарч эсвэл биеэ дааж, сургалт- арга зүйн асуудлыг шийдвэрлэж, шинэ мэдлэг эзэмшихэд оршино. Энэ арга сургалтыг судалгаатай холбож өгдөг. Энэ аргын үед бэлэн материалыг дэвшүүлж тавих бус, түүнийг үүсэл, хөгжлийнх нь явцад авч үзэх хэрэгтэй юм. Энэ үед оюутан хамтарч эрэл хайгууль хийж танин мэдэх үйл ажиллагаа нь улам идэвхждэг.

Лекцээ оюутанд ойлгуулж, мэдлэг олгоход нь тохирсон үг, өгүүлбэрийг зөв сонгох, хэл ярианы баялаг, сан, соёл эзэмшлэх явдал чухал. Багш хүн оюутантай ажиллах гол орчин болох хичээлийн танхимыг эзэмдэж үг хэллэгээ оновчтой сонгох ойлгуулах нь чухал юм. Аман ярианы онцлог юунд орших вэ? Аман яриа дэс дараалсан хэлний байдлаар цаг хугацааны хувьд хэрэгждэг бол бичгийн хэллэгийг номын үсэг, түүний харааны тусгал томъёололын илэрхийллийн хувьд орон зайд хэрэгждэг.

Аман ярианы 2 дах онцлог нь сэтгэл санааны хөдөлгөөнтэй байдал бий болгох. Яриандаа нийтлэг, оносон үг хэрэглэх илүү сайн ойлгоход туслах үлгэр дууриалтай арга хэрэгсэл хэрэглэснээр бий болдог. Мөн зарим үгийг цохож хэлэх, түр тасалддал бий болгож оюутанд анхаарлаа төвлөрүүлэх, багшид утга санаагаа бүрдүүлэх бололцоо олгоно. Түр амсхийлтээр бичгийн хэллэгт болохгүй (зэмлэл, зөвшөөрөхгүй байх, хүлээлт гаргах) олон тооны илэрхийллийг гаргаж болно. Мөн нэр болон үйл үгийг тусгайлан тод хэлэх үг өгүүлбэрийг оновчтой утгаар илэрхийлэх нь чухал. Түргэн ярих, уйтгартай, илэрхийлэх, шулга, чалчаа хэлэх, эмх замбараагүй ярих дутагдлыг тогтмол хийх дасгалаар засаж болно.

Аман ярианы 3 дах онцлог нь үг ярихгүйгээр утга санаагаа бүрэн илэрхийлэх, боломжтой. Ж= нь нүүр, нүднийхээ буюу биеийнхээ хөдөлгөөнөөр санаа бодлоо илэрхийлэх. Бодож санасан нь нүүр, нүдэндээ илэрдэггүй багшийн яриаг ойлгоход нилээд төвөгтэй. Өгүүлбэрийн зохион байгуулалт нь илүү энгийн байдагт 4 дэх онцлог оршино.

Хичээл үргэлжлэх хугацааны турш оюутны анхаарлыг татахын тулд багшийн үг яриа ямар байх ёстой вэ? Цохон тэмдэглэлтээ зөв хэлэх, үг яриагаа мэдлэгтэй тодорхой илэрхийлэх нь ярианы соёлын нэг элемент юм. Аман яриа нь шууд хүлээж авдагаараа сонсоход нилээд ядаргаатай гэдгийг бодолцож байх хэрэгтэй. Иймд багш хүний үг яриа дүрслэх чадвартай, биеийн хөдөлгөөнөөр санаагаа илэрхийлэх чадвартай болох ёстой. Үг яриа бодол, сэрлийг илэрхийлдэг, үүгээрээ үгүйсгэх, эсвэл нотлох чанартай, хүмүүсийн сэтгэл санаанд хувьсал өөрчлөлт үүсгэдэг талтай.